

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

№ 2023 / 19

БАТЛАВ:



ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

2023 оны 03-р сарын 15-ны өдөр	Дугаар	Улаанбаатар хот
ДААТГАЛЫН ХЭЛБЭР:	Жолоочийн Хариуцлагын Албан Журмын Даатгал	
ДААТГУУЛАГЧ:	АМЛГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК	
ХАЯГ, БАЙРШИЛ:	МОНГОЛ УЛС, БАЯН ДҮҮРЭГ 10-Р ХОРОО УС-15-1 Утас: И-Мэйл:	
ДААТГАЛЫН ЗҮЙЛ:	Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амьнас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготой бусдын өмнө хүлээх хариуцлага.	
ЭРСДЭЛИЙН НӨХЦӨЛ:	Гэрээнд заагдсан эрсдэл	
ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:	2023 оны 03 -р сарын 15 -ны өдрөөс эхлэн 2024 оны 03-р сарын 15-ийг дуустал	
ХАСАЛТ ХЭСЭГ:	Гэрээнд заасанчлан	
Албан журмын даатгалын үнэлгээ	70,000,000 төгрөг	
Албан журмын даатгалын хураамж:	1,006,425 төгрөг	
Мэргэшсэн жолоочийн даатгалын хураамж	191,400 төгрөг	
НИЙТ ХУРААМЖ	1,197,825 төгрөг	

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээ нь даатгуулагч даатгалын зүйлээ даатгагчид даатгуулах, даатгагч нь гэрээнд заасан эрсдэл үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Даатгалын баталгаа нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 1.3 Даатгагч, Даатгуулагч талууд (цаашид “Талууд”) Гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 1.4 Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү даатгалын үйлчлэх хүрээ нь Монгол улсын нутаг дэвсгэр байна.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1 Энэхүү гэрээнд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:
 - 2.1.1 “даатгагч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.3-т заасан даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулж, уг гэрээнд заасан нөхцөл, хэмжээгээр хохирогчид нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;
 - 2.1.2 “даатгуулагч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.4-т заасан “..... ХХК даатгагчтай гэрээ байгуулж, замын хөдөлгөөнд оролцох үедээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг”;
 - 2.1.3 “даатгалын баталгаа” гэж Даатгуулагчид олгох баталгаа бичиг, сертификатыг;
 - 2.1.4 “авто тээврийн хэрэгсэл” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.2-т заасан Автотээврийн 3.1.1-д” заасныг;
 - 2.1.5 “даатгалын нөхөн төлбөр” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.6-д заасан даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгө болон даатгалын гэрээгээр даатгалын нөхөн төлбөр олгох боломжгүй бол жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг;
 - 2.1.6 “жолооч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.1-д заасан “..... ХХК-н автотээврийн хэрэгсэл болон мотоциклийг жолоодож яваа хүнийг”; 2.1.6. “жолоочийн даатгалын тохиолдол” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.9-д заасан “..... ХХК-н жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж, хариуцлага хүлээх тохиолдлыг”;
 - 2.1.7 “хохирогч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.10-т заасан “Албан журмын жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдлын улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учирсан этгээд, эсхүл даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд гэм хор учруулсны төлбөрийг шаардах эрх бүхий этгээдийг” тус тус ойлгоно.

ГУРАВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

- 3.1 Энэхүү гэрээний даатгалын зүйл нь хавсралтан дахь тээврийн хэрэгслийг жолоодож буй жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготой бусдын өмнө хүлээх хариуцлага байна.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

- 4.1 Даатгуулагч нь дараах төрлийн эрсдэлийг даатгуулна. Үүнд:
 - 4.1.1 Жолооч нь авто тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь насанд учруулсан хохирол;
 - 4.1.2 Жолооч нь авто тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол;
 - 4.1.3 Жолооч нь авто тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эд хөрөнгөд учруулсан хохирол.

ТАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭМЖЭЭ

5.1 Даатгалын үнэлгээний хэмжээ нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу дараах хэмжээтэй байна: /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар тусгав/

5.2

	Тээврийн хэрэгслийн ангилал	Даатгалын үнэлгээ /төгрөг/
1	“А” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл
2	“В” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл
3	“С” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая хүртэл
4	“Д” ангиллын тээврийн хэрэгсэлд	10 сая хүртэл
5	“Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл

ЗУРГАА. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙГ ТӨЛӨХ ХУГАЦАА

6.1 Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо дор дурдсан даатгалын суурь хураамжийн хэмжээг Жолоочийн даатгалын тухай хуулийн 11.1-д заасан итгэлцүүрээр нэмэгдүүлж буюу хорогдуулж тооцно: /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар тусгав/

	Тээврийн хэрэгслийн ангилал	Даатгалын суурь хураамж /төгрөг/
1	“А” ангиллын тээврийн хэрэгсэл	12500
2	“В” ангиллын тээврийн хэрэгсэл	33000
3	“С” ангиллын тээврийн хэрэгсэл	42500
4	“D” ангиллын тээврийн хэрэгсэл	53000
5	“Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл	12500

6.2 Даатгалын хураамж төлөх хугацааг даатгалын гэрээнд тодорхой заана. Гэрээнд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тогтоосон хугацаанд гэрээнд заасан дүнгээр даатгалын хураамж төлөгдсөнөөр гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

6.3 Даатгуулагч гэрээний хавсралтанд заагдсан хураамжийг 2023 он 03-р сарын 15-ны өдрийн дотор “МИГ Даатгал” ХХК-ийн Төрийн Банкн дахь төгрөгийн 106000066025 тоот дансанд шилжүүлнэ.

6.4 Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.3-т заасны дагуу Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна.

6.5 Даатгуулагч нь энэхүү гэрээний 6.1-т заасны дагуу даатгалын хураамжийн дүнг даатгагчид төлнө.

6.6 Даатгалын хураамж бүрэн төлөгдсөнөөр даатгалын гэрээ хүчин төгөлдөр болно.

ДОЛОО. ДААТГАЛЫН ХУГАЦАА, ТҮҮНИЙГ ДАХИН СУНГАХ НӨХЦӨЛ

7.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 03 сарын 15-ний өдрөөс 2024 оны 03 сарын 15-ний өдрийн 24:00 цаг хүртэл хүчин төгөлдөр байна.

7.2 Гэрээний хүчинтэй хугацаанд даатгуулагч болон тээврийн хэрэгслийн өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү гэрээг дуусгавар болгож, гэрээний үлдэх хугацаатай тэнцэх хэмжээний даатгалын хураамжийг хувь тэнцүүлэн даатгуулагчид буцааж олгоно.

7.3 Гэрээний аль нэг тал нь гэрээний хугацааг сунгахыг хүсвэл гэрээний хугацаа дуусахаас хуанлийн 14 хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

7.4 Гэрээний 2 тал энэ гэрээний 7.3-т заасны дагуу гэрээг сунгахаар харилцан тохиролцсон бол энэ талаар гэрээнд тэмдэглэх ба энэ гэрээний 6.3-д зааснаар даатгалын хураамж бүрэн төлөгдсөнөөр гэрээ хүчин төгөлдөр болно.

7.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.6 Гэрээний хавсралт болон бусад дагалдах баримт нь гэрээний салшгүй хэсэг байна.

7.7 Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын баталгааг бусад дамжуулахыг хориглоно.

7.8 Даатгалын гэрээний хугацааг талууд харилцан тохиролцож тогтоох бөгөөд сунгаж болно.

НАЙМ. ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1 Даатгагч дараах эрх эдэлнэ:
- 8.1.1 даатгагч нь нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардах;
 - 8.1.2 Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.2-т заасны дагуу даатгалын тохиолдол болсон газар нутгийн байршлыг харгалзан даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь энэхүү гэрээний 8.2.3-т заасан хугацааг хохирогч, даатгуулагчийн зөвшөөрлийн дагуу 10 хүртэл хоногоор сунгах.
- 8.2 Даатгагч дараах үүрэг хүлээнэ:
- 8.2.1 Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;
 - 8.2.2 даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;
 - 8.2.3 даатгуулагч өргөдөл гаргаснаас хойш 3 хоногийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж, даатгалын хохирол үнэлэгчийг томилох;
 - 8.2.4 даатгагч даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг хариуцах;
 - 8.2.5 даатгалын гэрээний хугацаанд бий болсон уг гэрээтэй холбоотой бүхий л мэдээллийг даатгуулагчид үнэ төлбөргүй гаргаж өгөх;
 - 8.2.6 даатгалын гэрээ байгуулсан даруйд гэрээ байгуулсныг гэрчлэх даатгалын баталгааг даатгуулагчид өгөх.

ЕС. ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 9.1 Даатгуулагч дараах эрх эдэлнэ:
- 9.1.1 даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
 - 9.1.2 Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.4, энэхүү гэрээний 8.2.3-т заасны дагуу даатгагч нь хуульд заасан хугацаанд даатгалын хохирол үнэлэгчийг томилоогүй бол даатгуулагч нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч этгээдэд хандах.
- 9.2 Даатгуулагч дараах үүрэг хүлээнэ
- 9.2.1 даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хэмжээ, хугацаанд даатгагчид төлөх;
 - 9.2.2 даатгал хийлгэхтэй холбоотой баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;
 - 9.2.3 жолоочийн даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;
 - 9.2.4 даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын баталгааг шалгуулах;
 - 9.2.5 даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн болон эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд гаргаж өгөх;
 - 9.2.6 даатгагч нь дампуурсан бол шуурхай албанд болон шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх.
- 9.3 Тээврийн хэрэгслийн жолооч нь энэ гэрээний 9.2.3-9.2.6-д заасан үүргийг хүлээнэ.
- 9.4 Даатгуулагч даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягтыг даатгалын тохиолдол гарсан даруйд бөглөж, гарын үсэг зурна.
- 9.5 Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол энэ тухайгаа даатгагчид мэдэгдэх бөгөөд даатгагчаас эргэн төлүүлэхээр даатгагчийн зааврын дагуу хохирлыг жолооч барагдуулж болно.
- 9.6 Даатгуулагч Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.4 болон энэ гэрээний 9.2.3-9.2.6, 9.5-д заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгуулагч өөрөө хариуцна.

АРАВ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛ

- 10.1 Даатгагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг Жолоочийн даатгалын тухай хуулийн 17-д заасныг үндэслэн дараах журмын дагуу тодорхойлно:
- 10.1.1 хохирогч нас барсан бол Иргэний хуулийн 508 дугаар зүйлд заасны дагуу;
 - 10.1.2 хохирогчийн эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талууд санал нэгдсэн бол тэдгээрийн харилцан тохиролцсон хэмжээгээр;
 - 10.1.3 хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол Иргэний хуулийн 505 дугаар зүйлд заасны дагуу;
 - 10.1.4 хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол Иргэний хуулийн 510 дугаар зүйлд заасны дагуу.
- 10.2 Даатгагч хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт, Жолоочийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтооно:
- 10.2.1 Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон эсэхээс үл хамааран даатгагч нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 16, 17, энэ гэрээний 10.1-д заасан журмын дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш ажлын 10 өдрийн дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.
 - 10.2.2 Хохирогчийн эд хөрөнгөд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд Жолоочийн даатгалын тухай хуулийн 16, 17 энэ гэрээний 10.1- д заасан журмын дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш 1 сарын дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.
 - 10.2.3 Даатгагч нь хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа хохирогчтой тохиролцсоны дагуу даатгалын үнэлгээнд багтаан эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.
 - 10.2.4 Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоох хүртэл хохирогчийн хүсэлтийн дагуу нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгож болно.
 - 10.2.5 Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоохоос өмнө хэд хэдэн хохирогчийн хүсэлтээр нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгохоор бол эхний удаад хохирогч бүрт ижил хэмжээгээр, хохирлын хэмжээ бүрэн тогтоогдсоны дараа хувь тэнцүүлэн олгоно.
 - 10.2.6 Хэд хэдэн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйл, энэ гэрээний 5.1-д заасан хэмжээнээс хэтэрсэн бол хохирогч бүрт олгох нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн олгоно.
 - 10.2.7 Хохирогчид олгох нөхөн төлбөрийн 80 хүртэл хувийг хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохиролд, 20 хүртэл хувийг хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохиролд олгоно.
 - 10.2.8 Тээврийн хэрэгслийн өмчлөгчийн тээврийн хэрэгслийг мэргэшсэн жолооч болон “С”, “Д” ангилалаар даатгуулсан даатгуулагч жолоодож байх үед үүссэн даатгалын тохиолдол бүрд нөхөн төлбөрийг даатгуулагч тус бүрийн төлсөн даатгалын хураамжийн харьцаагаар даатгагч тус бүр хариуцан төлнө.
- 10.3 Даатгагч нь Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу дараах баримтыг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно:
- 10.3.1 даатгалын гэрээ;
 - 10.3.2 даатгуулагчийн өргөдөл;
 - 10.3.3 шаардлагатай бусад баримт бичиг.
- 10.4 Дараах хохирол жолоочийн даатгалын тохиолдолд үл хамаарна гэж үзэн даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзана:
- 10.4.1 сэтгэл санааны хохирол;
 - 10.4.2 хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;
 - 10.4.3 даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол;
 - 10.4.4 Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.

АРВАН НЭГ. НӨХӨН ТӨЛБӨРИЙГ БУЦААН НЭХЭМЖЛЭХ ҮНДЭСЛЭЛ

- 11.1 Даатгагч нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:
- 11.1.1 хохирогчид хохирол учирсан нь даатгуулагчийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;
 - 11.1.2 даатгалын тохиолдол гарсан талаар Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос;
 - 11.1.3 даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас;
 - 11.1.4 даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас;
 - 11.1.5 хуульд заасан бусад тохиолдолд буруутай этгээдээс.

АРВАН ХОЁР. ГЭРЭЭГ ДҮГНЭХ, ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

- 12.1 Энэхүү гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно:
- 12.1.1 гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
 - 12.1.2 даатгагч, даатгуулагчийн аль нэг нь дампуурсан, татан буугдсан;
 - 12.1.3 даатгуулсан тээврийн хэрэгслийн өмчлөгч өөрчлөгдсөн;
 - 12.1.4 талууд харилцан тохиролцож гэрээг цуцалсан.

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Даатгагчийн хаяг:

МОНГОЛ УЛС, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1р хороо, Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК ийн 106 тоот

Нөхөн төлбөрийн Албаны хаяг:

МОНГОЛ УЛС, Улаанбаатар-15170, Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө, 5/1, МИГ Даатгал ХХК-ны байр, ШХ-200
Шуурхай Алба 7575-6000,

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ЖАГСААЛТ

Даатгагч:
Даатгуулагч:

МИГ Даатгал ХХК
“Амгалан дулааны станц” ТӨХК

№	Машины марк	Улсын дугаар	Нэхэмжлэхийн дугаар	Байгууллагын регистр	Даатгалын үнэлгээ	Жолоочийн хариуцлагын даатгалын хураамж
1	Hyundai Starex	8019УБК	AJ2302020680011	6021646	10,000,000	143100
2	Hyundai Sonata	4560УБД	AJ2302020680012	6021646	5,000,000	89100
3	Hyundai Sonata	1199УНС	AJ2302020680013	6021646	5,000,000	89100
4	MINISUBISHI FUSO	2507УБН	AJ2302020680014	6021646	10,000,000	114750
5	Sinotruck HOWO	5653УБӨ	AJ2302020680019	6021646	10,000,000	149175
6	HYUNDAI Accent	4972УНВ	AJ2302020680015	6021646	5,000,000	89100
7	Xiamen XG951H	2598УН	AJ2302020680016	6021646	5,000,000	33750
8	Beiben North Benz	2874УНЯ	AJ2302020680017	6021646	10,000,000	149175
9	HOWO	4743УБӨ	AJ2302020680018	6021646	10,000,000	149175
	Нийт				70,000,000	1006425

Гэрээний эхлэх хугацаа: 2023 оны 03 дугаар сарын 15-ний өдрөөс

Дуусах хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 24:00 цаг хүртэл

Даатгуулагчийг төлөөлж:

Хуулийн мэргэжилтэн
Г.Саруул

.....\

ААХХ-н дарга

Автомеханик инженер

Санхүү Эдийн засгийн дарга
Ө.Удвал

.....\

Г.Баттулга

.....\

Н.Сайнбилэг

.....\

Даатгагчийг төлөөлж :

Менежер

Ч.Мөнгөнцэцэг

.....\

МЭРГЭШСЭН ЖОЛООЧИЙН ДААТГАЛ

Даатгагч: МИГ Даатгал ХХК
 Даатгуулагч: “Амгалан дулааны станц” ТӨХК


№	Овог нэр	Регистрийн дугаар	Жолооны үнэмлэх дугаар	Мэргэшсэн жолоочийн даатгалын хураамж	Гэрээний дугаар
1	Жамган Алтантулга	АЮ70092273	37423	16500	AJ2302020680021
2	Буянтогтох Батбаяр	ОП91082519	671932	29700	AJ2302020680022
3	Батпүрэв Алтангэрэл	РЭ88102474	462973	28050	AJ2302020680023
4	Энх-Амгалан Цогтсайхан	АЭ75111671	ОО65470	16500	AJ2302020680024
5	Шарав Сандагсүрэн	УГ70062511	О38711	19800	AJ2302020680031
6	Санжпэрэнлэй Төмөрцоож	АЖ66101515	134283	24750	AJ2302020680027
7	Дорждэрэм Эрболд	РГ90060710	656268	28050	AJ2302020680029
8	Дашбазар Сэрүүнтамир	УЮ95022318	ОО75173	28050	AJ2302020680030
	Нийт			191400	

Гэрээний эхлэх хугацаа: 2023 оны 03 дугаар сарын 15-ний өдрөөс
 Дуусах хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 24:00 цаг хүртэл
Даатгуулагчийг төлөөлж:

Хуулийн мэргэжилтэн
 Г.Саруул



Санхүү Эдийн засгийн дарга
 Ө.Удвал




ААХХ-н дарга

Г.Баттулга



Автомеханик инженер

Н.Сайнбилэг



Даатгагчийг төлөөлж :

Менежер
 Ч.Мөнгөнцэцэг

